



АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ



Тендер шалгаруулалтын нэр

“Шивээ овоо” ХК-д МПЭ 1120 маркийн
өргөхийн хөдөлгүүр засварын ажил гүйцэтгэх
гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт

Тендер шалгаруулалтын дугаар

ШО/202009400

Огноо

2020.09.25

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2020.09.25**

Тендер шалгаруулалтын нэр:

МПЭ 1120 маркийн өргөхийн хөдөлгүүр засварын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт

Тендер шалгаруулалтын дугаар: **[ШО/202009400]**

[“Шивээ Овоо” ХК] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[МПЭ 1120 маркийн өргөхийн хөдөлгүүр засварын ажил]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татан авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **[2020 оны 10-р сарын 02]** өдрийн **[10 цаг 30 минут]** --аас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 10-р сарын 02]**-ны өдрийн **[10 цаг 40 минут]-аас [Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн албаны өрөө]**¹-д нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг, бусад мэдээллийг tender.gov.mn, shivee-ovoo.mn сайтаас болон доорх утсаар лавлаж болно.

[Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, “Шивээ Овоо” ХК, Худалдаа хангамжийн алба]

[Утас: 88099400, 99029879, 99903261]

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1. Сүүлийн [2019 он] аудитлагдсан санхүүгийн тайлан</p> <p>2. Сүүлийн [2019 он] туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар</p> <p>3. Борлуулалтын хэмжээ: [Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь тендерт ирүүлж буй үнийн саналын мөнгөн дүнгийн 50% -с багагүй байна.]</p> <p>4. Ижил төстэй ажлын өртөг: [2020 онд тендерт ирүүлж буй үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-аас багагүй үнийн дүнтэй тогтмол гүйдлийн хөдөлгүүр засварын ажил гүйцэтгэсэн байна.]</p> <p>5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө: [Тендерт ирүүлж буй үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй байна] Үүнд: <i>Байгууллагын дансны үлдэгдэл баталгаажуулсан харилцагч банкны тодорхойлолтыг тооцно</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч тендерийн материалыг цахим хэлбэр /PDF/-ээр ирүүлнэ.</p> <p>Огноо: [2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, өөрийн оффисе, ХХАлбаны өрөө]</p> <p>Огноо: [2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 40 минут]</p>
	<ol style="list-style-type: none"> 1. Компаний танилцуулага 2. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт 5. Гэрээний үнэ, хугацаанд техникийн тодорхойлолтын дагуу засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн актаар хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл 6. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын дагуу засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн актаар хүлээлгэж өгөөгүй мөн чанар стандартын шаардлага хангаагүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл 7. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон үнээр хугацаанд нь засварын ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан мэдэгдэл

ТООЗ 4.1	Тендерийн үнэ: <i>[Тохируулгагүй тогтмол байна.]</i>
ТООЗ 5.1	Техникийн тодорхойлолт: <i>[Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.]</i>
ТООЗ 6.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Ажилбарууд	Хийгдсэн эсэх		Тайлбар	
		Тийм +/	Үгүй -/		
1	Задаргаа болон хэмжилт хийх ажилбар	Хөдөлгүүр задлах		-	
2		якорьт хэмжилт хийж, гэмтэл тодорхойлох	+		
3		Даралттай хийгээр үлээлэг хийх, цэвэрлэх	+		
4		Цэвэрлэгээ хийх	+		
5		Угаалга хийх	+		техникийн содтой ус, бензин
6		Хатаалга хийх	+		
7		Хэмжилт хийх	+		
1	Якорьт хийх ажилбарууд	Хэмжилт хийж гэмтэлтэй секцийг тодорхойлох	+		
2		Бандаж авах	+		
3		Гагнуур салгах	+		
4		Секц ороомог сугалах	+		
5		Гэмтэлтэй секц ороомгийг тодорхойлох	+		
6		Секц ороомгийн тусгаарлалыг сэргээж ороох	+		Стекло лент, следа лент,
7		Секц ороомгийн үзүүр цэвэрлэх	+		Зүлгүүр
8		Секц ороомгийн үзүүрийг тугалагадах	+		Тугалага- пос 40 спирт
9		Коллекторын гэмтэл тодорхойлох	+		
10		Коллекторын задаргаа хийх	+		
11		Гэмтэлтэй ялтас солих		-	
12		Коллекторын ялтас цэвэрлэх		-	
13		Коллектор угсарч, хэмжилт хийх	+		
14		Секц ороомог суух ховил цэвэрлэх	+		Зүлгүүр
15		Зүрхэвчний гэмтэл тодорхойлж, түүнд засвар хийх		-	
16		Секц ороомог суулгахад бэлдэх	+		
17		Секц ороомог суулгах	+		
18		Эсэргүүцлийн хэмжилт хийх	+		
19		Секц ороомгийн коллекторт гагнах	+		Тугалга спирт
20		Гагнуурыг шалгаж хэмжилт хийх	+		
21		Бандаж ороох	+		Бандажны лент
22		Бандаж шарж хатаах	+		
23		Тусгаарлагч лакаар нэвчээх	+		Лак
24		Нэвчээсэн лакаг хатаах	+		
25		Коллекторын ялтас хоорондыг тусгаарлаж замыг татах	+		
26		Ялтасны ирмэгт паск гаргах	+		
27		Тусгаарлах /изоляцияц/ будгаар будах	+		Тусгаарлагч будаг
28		Туршилт	+		Экскаваторт дээр ажиллуулж
29		Токарьт зоролт, хэмжилт, өнгөлгөө хийх	+		

Хийгдэх ажилбарын дараалалаар үнийн саналын задаргааг ирүүлнэ.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(“Шивээ Овоо” ХК)-ийн гүйцэтгэх захирал Ц. Энхтүвшин танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар,**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

үйлчилгээний гарын авлага	болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
	17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
18. Гэрээг цуцлах	18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
	18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: <ul style="list-style-type: none"> (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
	18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
	19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
20. Гүйцэтгэлээс чөлөөлөх	20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[МПЭ 1120 маркийн хөдөлгүүр засварын ажил гүйцэтгэх]</i> <i>[ШО/202009400]</i>
ГЕН 2.1	Ажил: <i>[МПЭ 1120 маркийн хөдөлгүүр засварын ажил]</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[Ө. Баяржаргал Утас: 99022201]</i>
ГЕН 4.1	Ажил гүйцэтгэх хугацаа: <i>[7-10 хоног]</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[3]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Зөрчил гологдол арилгах: <i>[Шалгалт туршилтын болон баталгаат хугацаанд зөрчил гологдол илэрсэн тохиолдолд гүйцэтгэгч нь захиалагчийн заасан хугацаанд өөрийн зардлаар засварлана.]</i>
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: <i>[6 сар]</i>
ГЕН 15.1	Хүлээлгэн өгөх: <i>[Хөдөлгүүр засварын ажил үйлчилгээг хийж актаар хүлээлгэж өгнө.]</i>

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

Арав. ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁵

БАТЛАВ
“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

БАТЛАВ
“.....” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ЭНХТҮВШИН

..... / овог нэр /

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20... оны дүгээр сарын

№

Сэвхүүл

Нэг талаас: Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд байрлах, 2004879 регистрийн дугаартай “Шивээ-Овоо” ХК/цаашид “Худалдан авагч” гэх/ түүнийг төлөөлж Худалдаа, Хангамжийн Албаны дарга Б.Чинбэлэг,

Нөгөө талаас:хот,дүүрэг,тоотод байрлах, тоот регистрийн дугаартай “.....” ХХК/цаашид “Худалдагч” гэх/ түүнийг төлөөлжалбан тушаал овог нэр/цаашид хамтад нь “Талууд” гэх/ ТБОНӨХБАҮХАТХуулийн 33.1, 33.2 дахь заалт болон Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь “Ажил гүйцэтгэгч” нь, “Захиалагч”-ийн ашиглаж байгаа “ЭШ-25/90 экскаваторын МПЭ-1120-630УХЛЗ маркийн хөдөлгүүр” засварын ажлыг хийж гүйцэтгэхэд оршино.

Хоёр. Гэрээний ажлуудыг гүйцэтгэх хугацаа

- 2.1. “Гүйцэтгэгч” эд ангийг их засварт хүлээн авсан өдрийн маргаашаас эхлэн ажлын 10 хоногт багтаан их засварыг хийж гүйцэтгэнэ.

Гурав. Төлбөр, тооцоо

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх засварын ажлын нийт зардал /.....тоо...../үсэг...../ болно. Ажлын нийт зардалд (НӨАТ орсон) дүн болно.

- 3.2. “Захиалагч” нь засварын ажлыг бүрэн гүйцэтгэж, акт үйлдэн хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын дотор “Гүйцэтгэгч” талд төлнө.

Дөрөв. “Захиалагч”-ийн эрх, үүрэг

- 4.1. Засварын ажлын хөлс, сэлбэг материалын үнийг энэхүү гэрээний 3.2-т заасан хугацаанд нь төлнө.

- 4.2. “Захиалагч” их засвар хийгдсэн эд ангийг техникийн шаардлагад нийцсэн шатах тослох материалаар хангаж, техник ашиглалтын заавар зөвлөмжийн дагуу зөв ажиллуулах, тестийн хугацаанд хэт ачаалал өгөхгүй байх, техникийн ээлжит үйлчилгээг цаг тухайд нь бүрэн хийж байх үүргийг хүлээнэ.

⁵ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

4.3. “Ажил гүйцэтгэгч”-ийн хийж гүйцэтгэсэн ажил нь чанарын доголдолтой бол энэ талаар гомдлоо баталгаат хугацааны туршид мэдэгдэх, уг доголдлыг арилгахыг “Ажил гүйцэтгэгч”-ээс шаардах эрхтэй.

4.4 “Захиалагч” нь ажлын явцыг хянах, чанарыг шалгах, “Ажил гүйцэтгэгч”-ээс гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

4.5. “Захиалагч” нь чанарын шаардлага хангаагүй, дутуу, бүрэн бус засварын ажлыг хүлээн авахгүй байх эрхтэй.

Тав. “Ажил гүйцэтгэгч”-ийн эрх, үүрэг

5.1. Их засварын ажлын график төлөвлөгөөг “Захиалагч”-тай зөвшилцөн товлох ба цаг алдалгүй чанартай хийж гүйцэтгэнэ.

5.2. Ажил эхлэхээс өмнө захиалагч талын ХАБЭА хэлтсээс хөдөлмөр аюулгүй байдлын анхан шатны зааварчилгаа авна.

5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас өгсөн зааврын дагуу ажлыг гүйцэтгэн захиалагчид тайлагнаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөж ажиллана.

5.4. Гүйцэтгэсэн ажил нь шаардлага хангаагүй тохиолдолд түүнийг дахин засварлана.

5.5. Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт болон, дүрэм, журам нормуудыг чандлан мөрдөж ажиллах. Ажил гүйцэтгэх хугацааны ХАБЭА-тай холбоотой асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

5.6. Ажил гүйцэтгэгч талын ажилтнууд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд ажил гүйцэтгэгч тал нь ХАБЭА-н тухай хуулийн 29.1-д заагдсан арга хэмжээг шуурхай авах бөгөөд харьяа нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нарт мэдээлэх, 29.2-т заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комисс томилж судлан бүртгэх үүргийг хүлээнэ. Ингэхдээ Монгол улсын Засгийн газрын 2015 оны 269-р тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг мөрдөж ажиллах үүрийг хүлээнэ.

5.7. Гүйцэтгэсэн ажлын үр дүн аюулгүй ажиллагааны горим тайланд тусган захиалагч талд өгнө.

5.8. “Захиалагч”-ийн төлөөлөгчийг байлцуулан засварлагдах эд ангийг шалгаж акт баримт үйлдэн их засварт хүлээн авна.

5.9. Их засвар үйлчилгээ хийгдэх эд ангид бүрэн задаргаа хийж “Захиалагч” талын инженер механикуудыг байлцуулан эвдрэлийн акт тогтооно.

5.10. Захиалгат ажлыг зориулалтын багаж төхөөрөмжөөр мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн засварчид, үндсэн эд ангийн засварын инженерийн удирдлага дор технологийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд их засварын дараах туршилт, ажиглалтыг хийж цаашид ашиглах техникийн заавар, зөвлөмжийг “Захиалагч”-д гаргаж өгнө.

5.11. “Ажил гүйцэтгэгч” нь их засварт орж буй хөдөлгүүрт шинээр тавигдаж байгаа сэлбэг, эд ангиуд тавигдсан тохиолдолд “Захиалагч” талд хуучин сэлбэг эд ангиудыг акт үйлдэн хүлээлгэн үүрэгтэй.

5.12. “Ажил гүйцэтгэгч” нь их засвар хийсэн хөдөлгүүрийг техникт суурилуулж, асааж, шалгаж албан ёсоор хүлээлгэж өгнө.

Зургаа. Засварын ажлын баталгаа

6.1. Засвар хийгдсэн эд ангийг хоёр талын мэргэжлийн ажилтан хамтран шалгаж, акт үйлдэн хүлээлцэж “Ажил гүйцэтгэгч” нь баталгааны акт баримтыг “Захиалагч”-д гаргаж өгнө. Баталгаат хугацаанд гарсан эвдрэл, гэмтлийг “Гүйцэтгэгч” өөрийн зардлаар арилгана.

6.2. Баталгаат хугацаанд хийгдэх техникийн ээлжит үйлчилгээг “Ажил гүйцэтгэгч” тал “Захиалагч”-ийн ажлын байранд очиж хийж гүйцэтгэнэ.

6.3. Баталгаат хугацаанд гарч болох эвдрэл гэмтэл нь засварласан машиныг техникийн ашиглалтын зааврын дагуу ашиглах явцад мөрдөгдөнө.

6.4. Баталгаат хугацааны явцад засварласан эд ангид ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд “Захиалагч” ажлын 7 хоногийн дотор “Гүйцэтгэгч”-д албан бичгээр мэдэгдэнэ. “Ажил гүйцэтгэгч” албан

бичгийг хүлээн авч ажлын 3 хоногийн дотор хариу мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол тухайн газарт хүрэлцэн очиж үзлэг хийнэ. Хоёр талын хамтарсан техникийн комисс дүгнэлт гарган цаашид хийгдэх ажлыг зохион байгуулна

6.5. Засварласан эд ангид эвдрэл гэмтэл гарсны дараа албан мэдэгдэл өгөх хугацаа хүндэтгэх шалтгаангүйгээр өнгөрсөн буюу тухайн хугацаа хэт удаашрах, “Захиалагч” дур мэдэн эвдрэл гарсан эд ангийг задалж шалтгааныг тодруулах боломжгүй болгосон тохиолдолд захиалагчийн гаргасан нэхэмжлэл хүчингүйд тооцогдоно.

6.6. Засварласан эд ангид эвдрэл гарсан тухай албан мэдэгдлийг “Ажил гүйцэтгэгч” хүлээн аваад гэрээнд заасан 3 хоногийн хугацаанд хариу өгөөгүй буюу тохиролцсон хугацаанд очиж үзлэг хийж шалтгааныг тогтооход оролцоогүй тохиолдолд “Захиалагч”-ийн гаргасан дүгнэлтийн “Ажил гүйцэтгэгч” хүлээн авсанд тооцож “Ажил гүйцэтгэгч” өөрийн зардлаар гэмтсэн эд ангиудыг сольж эд ангийг сэргээн засварлана.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал болон талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

Найм. Талуудын хүлээх хариуцлага

8.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

8.2. Их засварт орсон техникт учирч болох аливаа эрсдэлийг засварт хүлээн авсан өдрөөс эхлэн “Ажил гүйцэтгэгч”, засварын ажил дуус ч “Захиалагч”-ид хүлээлгэн баталгаат хугацаа дууссан өдрөөс эхлэн “Захиалагч” хариуцна.

Ес. Бусад зүйл

9.1. Талууд харилцан тохиролцон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.

9.2. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж талууд үүргээ биелүүлснээр, эсвэл Талуудын аль нэг нь санаачилж гэрээг цуцалснаар дуусгавар болно.

9.3. Энэхүү гэрээ нь монгол хэл дээр хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд хувь бүр адил хүчинтэй байна.

9.4. Энэхүү гэрээтэй холбоотой үүссэн маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

9.5. Хэрэв Талууд харилцан тохиролцоо зөвшилцөлд хүрч чадахгүй бол Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

_____ С.Ариунзул
Санхүү Хангамжийн Хэлтсийн дарга

_____ Б.Чинбэлэг
Худалдаа хангамжийн албаны дарга

_____ Н.Энхжаргал
НББА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч

_____ Э.Мандахнаран
Хуулийн зөвлөх

Хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум
42020 Сэвхүүл
Утас: (976)-7054-6464
Факс:(976)-7054-6363

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

_____ / овог нэр /
Албан тушаал

Хаяг:хот,дүүрэг,хороо,
.....тоот
Утас:
Данс:...